



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн  
20 тоот Тогтоолыг Хавсралт

## ИНВЕСКОР ББСБ-ЫН ШҮГЭЛ ҮЛЭЭХ ЖУРАМ

IC-47 V-3.0

2022 он

Хамрах хүрээ: ИНВЕСКОР ББСБ ХК түүний охин компаниуд	Хариуцах эзэн: Инвескор ББСБ-ын Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар
Хувийг хадгалах: Төлөөлөн удирдах зөвлөл, Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар	Танилцах: ИНВЕСКОР ББСБ ХК болон охин компанийн бүх ажилтан
Хүчинтэй хугацаа: 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн	Хуудасны тоо: 7 хуудас
Дараагийн үнэлгээ хийх огноо: 2023 оны 06 сарын 22-ны өдөр	
Журмын дугаар: ИС-47	Хувилбар: V-3.0

**Өөрчлөлтийн түүх**

#	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-1.0	2020.09.16	Анх боловсруулсан.
2.	V-2.0	2022.01.11	Жил тутмын журмын үнэлгээний хүрээнд өөрчлөлт оруулав.
3.	V-3.0	2022.06.22	Компанийн засаглалын кодексын шинэчлэлтэд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулав.
4.			
5.			

**АГУУЛГА**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	1
2. НЭР ТОМЬЁО.....	1
3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ .....	1
4. ШҮГЭЛ ҮЛЭЭХ .....	1
5. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ.....	2
6. ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ .....	3
7. ХАРИУЦЛАГА .....	3
ХАВСРАЛТ 1. ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ.....	4

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Инвескор ББСБ” ХК болон түүний охин компаниуд /цаашид хамтад нь “ББСБ” гэх/-ын шүгэл үлээх үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим, шүгэл үлээх процесс, зөрчил шалган шийдвэрлэх, шүгэл үлээгчийн мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

## 2. НЭР ТОМЬЁО

- 2.1. Энэхүү журамд дурдагдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1. “Шүгэл үлээх” гэж ББСБ-ын дотоод дүрэм журмын зөрчил, хууль бус үйлдлийг илрүүлэх, дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор мэдээлэх үйл ажиллагааг;
  - 2.1.2. “Шүгэл үлээгч” гэж ББСБ-ын дотоод дүрэм, журмын зөрчил, хууль бус үйлдлийг илрүүлсэн, мэдээлэх үүргээ биелүүлж буй ажилтныг тус тус ойлгоно.

## 3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1. ББСБ нь дотооддоо шүгэл үлээх соёлыг бий болгох зорилгоор дараах зарчмуудыг баримтална. Үүнд:
  - 3.1.1. ББСБ-ын дотоод дүрэм журам, бодлогын хэрэгжилтийг хангах, дагаж мөрдөх, биелүүлэх нь ББСБ-ын ажилтан бүрийн үүрэг байна.
  - 3.1.2. ББСБ-ын дотоод дүрэм, журмыг зөрчсөн, ёс зүйгүй, шударга бус үйлдэл, байгууллагын болон ажилтнуудын ашиг сонирхол, аюулгүй байдлын эсрэг үйлдэлтэй тэмцэх нь ажилтан бүрийн үүрэг байна.
  - 3.1.3. ББСБ-ын ажилтан бүр зөрчлийг нэн даруй мэдэгдсэнээр байгууллага болон ажилтныг хамгаалах, зөрчлийг таслан зогсоох, учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсхүл бууруулах ач холбогдолтой гэдгийг ойлгож ухамсарлана.
  - 3.1.4. ББСБ нь шүгэл үлээсэн ажилтныг ямар ч тохиолдолд хамгаалж, шүгэл үлээгчийн талаарх мэдээллийг чандлан нууцална.
  - 3.1.5. Шүгэл үлээсэн ажилтны мэдээллээр байгууллагад учирч болзошгүй байсан эрсдэлийг бууруулсан, таслан зогсоосон, хууль эрх зүйн, зээлийн, санхүүгийн, нэр хүндийн болон аливаа эрсдэл гарахаас сэргийлсэн гэж үзсэн тохиолдолд шүгэл үлээж зөрчил мэдээлсэн ажилтныг урамшуулна.
  - 3.1.6. ББСБ нь зүй бус үйлдлийг өөгшүүлэхгүй, таслан зогсоох арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.
  - 3.1.7. ББСБ нь баримт нотолгоогүй эсхүл зөрчил хэмээн тогтоогдоогүй ямар ч тохиолдолд ажилтанд сахилгын шийтгэл оногдуулахгүй.

## 4. ШҮГЭЛ ҮЛЭЭХ

- 4.1. ББСБ-ын ажилтан бүр байгууллагын болон ажилтнуудын ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн, ББСБ-ын дотоод дүрэм, журам зөрчигдсөн, бизнесийн болон ажилтны ёс зүйн дүрмийг зөрчсөн, зүй бус үйлдлийг

мэдсэн тохиолдолд энэ тухай нэн даруй доорх сувгуудын аль нэгийг ашиглан ББСБ-ын Дотоод аудитын газрын захиралд шүгэл үлээж мэдээлнэ. Үүнд:

- 4.1.1. [whistleblowing@invescore.mn](mailto:whistleblowing@invescore.mn) цахим мэйлээр;
  - 4.1.2. Биечлэн уулзах;
  - 4.1.3. Бичгээр;
  - 4.1.4. Утсаар (ДАГ захирлын утас).
- 4.2. Шүгэл үлээгч нь зөрчлийн талаар мэдээлэхдээ үнэн бодит үйлдэл, баримтын талаар мэдсэн, харсан зүйлээ мэдэгдэнэ.
  - 4.3. Шүгэл үлээгч нь өөрийн мэдээлсэн зөрчлийг нотлох үүрэг хүлээхгүй боловч зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, үнэн зөв шийдвэр гаргаж цаашид авах арга хэмжээг цаг алдалгүй авахад туслах зорилгоор зөрчлийн талаарх нэмэлт мэдээлэл, нотлох баримтыг гаргаж өгч болно.

## 5. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Хууль тогтоомж, ББСБ-ын дотоод дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг тогтоох, тэдгээрийг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авах, зөрчлийн үндэслэлийг шалган тогтоох, дүгнэлт гаргах хяналт шалгалтын чиг үүргийг ББСБ-ын Дотоод аудитын газар хэрэгжүүлнэ.
- 5.2. ДАГ-ын аудитор нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
  - 5.2.1. Шүгэл үлээсэн мэдээллийг энэ бодлогын 4.1-т заасан сувгуудаар хүлээн авч бүртгэх;
  - 5.2.2. Шүгэл үлээгч өөрөө зөвшөөрсөн эсхүл хүссэн тохиолдолд шүгэл үлээгчтэй уулзах, нэмэлт тайлбар, санал сонсох, холбогдох нотлох баримт, баримт бичгийг хүлээн авах;
  - 5.2.3. Шүгэл үлээсэн мэдээлэлтэй танилцаж, холбогдох шалгалтыг хийж, дүгнэлт гаргах;
  - 5.2.4. Дүгнэлтэд үндэслэн авах арга хэмжээний талаар холбогдох нэгжид мэдээлэх, үүрэг өгөх, хамтран арга хэмжээ авах.
- 5.3. ДАГ-ын захирал нь зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэн, дүгнэлт гаргана.
- 5.4. ДАГ-ын шалгалт, дүгнэлтээр ажилтны гаргасан зөрчил нотлогдоогүй бол шүгэл үлээгчийн мэдээллийг хаах ба энэ талаар шүгэл үлээгчид мэдэгдэнэ. Шүгэл үлээгчийн мэдээлэл нотлогдоогүй, зөрчлийн шинжгүй байх нь тухайн шүгэл үлээсэн ажилтанд хариуцлага тооцох үндэслэл болохгүй.
- 5.5. ДАГ-ын шалгалт, дүгнэлтээр шүгэл үлээгчийн мэдээлэл үндэслэл бүхий, зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдвол зөрчлийн харьяаллыг тогтоож Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 5.6. Зөрчил гаргасан ажилтны албан тушаал болон чиг үүрэг, ажлын байран дахь нэр хүнд, туршлага нь түүний зөрчлийг шийдвэрлэхэд нөлөөлөх болон шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй.
- 5.7. Ажилтны ёс зүйн зөрчлийн шинж байдал, хор уршиг, ББСБ-д учруулсан хохирлын хэмжээ, анх үйлдсэн, давтан үйлдсэн зэргийг харгалзан үзэж ББСБ-ын Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

- 5.8. Гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрсөн тохиолдолд ББСБ-ын дотоод дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл, зөрчлийн үр дагавар, учруулсан эрсдэлийн талаарх мэдээллийг нийт ажилтнуудад урьдчилан сэргийлэх зөвлөмж болгон хүргүүлж болно. Энэ тохиолдолд зөрчил үйлдсэн, зөрчилд холбогдсон этгээдийн нэр, хувийн мэдээллийн нууцлалыг хадгалж, нууц мэдээллийг нийтэд ил болгохгүй.

## **6. ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ**

- 6.1. ДАГ болон шүгэл үлээсэн мэдээлэлтэй танилцсан, шийдвэрлэсэн, хянасан зэрэг эрх бүхий албан тушаалтан нь ямар ч тохиолдолд шүгэл үлээгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална.

## **7. ХАРИУЦЛАГА**

- 7.1. ББСБ-ын ажилтан нь байгууллагын болон ажилтнуудын ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн, ББСБ-ын дотоод дүрэм, журам зөрчигдсөн, бизнесийн болон ажилтны ёс зүйн дүрмийг зөрчсөн, зүй бус үйлдлийг мэдсээр байж мэдээлэхгүй өнгөрөөсөн нь түүнд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.
- 7.2. Энэхүү журмыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтан болон ажилтанд ББСБ-ын Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэмд заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.
- 7.3. Энэхүү журмын 6.1-д заасан эрх бүхий албан тушаалтан нь шүгэл үлээгчтэй холбоотой аливаа мэдээллийг задруулсан тохиолдолд ББСБ-ын Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэмд заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

--ooOoo--

ХАВСРАЛТ 1. ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ



